

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ 03 ДУГААР
САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Чойр

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2025 оны 03 дугаар сард Монгол улсын хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль болон холбогдох хууль, тогтоол, захирамж, заавар, журмыг мөрдөн ажиллаа.

**Нэг. Удирдлага, зохион байгуулалт,
Дээд байгууллагын тушаал шийдвэрийн биелэлт**

Энэ сард аймгийн Тамгын газрын хэлтсүүд, сумдын тамгын газар, аймгийн Онцгой байдлын газар зэрэг газруудтай хамтран ажиллах аймгийн ард иргэд, аж ахуй нэгж байгууллагад цаг агаарын урьдчилсан мэдээ, болзошгүй аюулт үзэгдэл, өдөр тутмын цаг агаарын мэдээ болон холбогдох мэдээллээр үйлчлэн ажиллаж байна.

Мөн сар бүр гаргаж явуулах тайлан, мэдээний жагсаалт гарган холбогдох дээд байгууллага, агентлагад хүргүүлэн мэдээллэн ажиллаж байна.

**Хоёр:Сургалт сурталчилгаа, мэдээ мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх олон
нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар**

Ус, цаг уурын урьдчилсан мэдээг хэрэглэгчдэд шуурхай хүргэх, тэднийг байгалын аюулт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх ажлын хүрээнд өдрийн болон хоногийн, тав ба долоо хоногийн, сарын цаг агаарын урьдчилсан мэдээ, дулаан, хүйтний улиралын төлөв, тойм, аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээг боловсруулан аймаг сумдын ЗДТГазар, багийн дарга нар, олон нийтийн ажилтан, Онцгой байдлын газар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг байгууллагад мэдэгдэх ба <http://govisumber.weather.gov.mn> болон <http://govisumber.namem.gov.mn> вэб сайтад байршуулж ард иргэдэд өөрийн аймгийн цаг агаарын мэдээг хурдан шуурхай, хялбар авах боломжийг бий болгон ажилласан.

Гурав: Шинжилгээ, судалгаа, хөтөлбөрт ажлын талаар

Энэ сард тус төвөөс 8-н хугацааны мэдээг нийт 248, климат агро дундаж мэдээ ХАА-н тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан. Цаг агаарын нарийвчилсан урьдчилсан мэдээ өглөө 7 цаг 30 минутаас өмнө, нэг хоногийн урьдчилсан мэдээг 12 цагаас өмнө, 5 хоногийн урьдчилсан мэдээг 16 цагаас өмнө сервэрт байршуулж, <http://govisumber.weather.gov.mn> веб сайтанд нарийвчилсан болон хоногийн тойм мэдээг 9 цаг 30 минутын дотор, 1-5 хоногийн урьдчилсан мэдээг 14 цаг 30 минутын дотор, 7 хоногийн төлөв, 7 хоногийн тойм мэдээг даваа гариг бүр, сарын урьдчилсан мэдээг 25-ны өдрийн дотор, сарын тойм мэдээг 5-ны өдрийн дотор тус тус веб сайтанд байршуулж ажиллалаа.

Уур амьсгал: 03-р сарын 20-ны байдлаар цаг уурын тойм мэдээ:

Цас ороогүй. Салхи ихэнхи хугацаанд 6-11 м/сек, зарим үед 13-16 м/сек хүрч салхилсан. Агаарын дундаж температур -6,6 градус хүйтнээс 2,1 градус дулаан байна, хамгийн хүйтэн нь 15-ны шөнө -15,7 градус хүйтэн, хамгийн дулаан нь 20-ны өдөр 14,0 градус дулаан байсан.

Хөдөө аж ахуй: Мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн худгийн усаар усалж байна.

Агаарын шинжилгээний ажил: Энэ сард тус 2 элемент буюу азотын давхар исэл (NO_2) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO_2) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 29 удаа мөн шинжилгээг 9 удаа, 3-р сарын 1-ээс 3-р сарын 19-ны дээжид шинжилгээ хийсэн дундаж азотын давхар исэл (NO_2) 0.016 мкг/м^3 сарын хүлцэх агууламж хэмжээ мкг/м^3 0.200

хүхэрлэг хийн давхар исэл (SO_2) 0.010 мкг/м^3 байна. сарын хүлцэх агууламж хэмжээ 0.450-тай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Тоосонцрын шинжилгээний ажил: Агаар дахь жижиг ширхэгт тоосонцор 3-р сарын 1-нээс 3-р сарын 19-ны $\text{PM}_{2.5}$ -ын дундаж 0.011 мкг/м^3 хүлцэх агууламжийн хэмжээ 50 мкг/м^3 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Уналтын сорьц: 2025 оны “3-р сарын 1-нээс 3-р сарын 31-ыг хүртэл уналтын сорьцноос дээж авч тайланг 3 удаа Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хүргүүлэн ажиллаж байна.

Хаягдал бохир усны хяналт-шинжилгээ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усны орох, гарах 2 цэгээс хаягдал усны сорьц авч химийн найрлага болон чанарын үзүүлэлтийг тодорхойллоо

Шинжилгээний дүнг /MNS4943:2015/ “Хаягдал ус”-ны стандартад харьцуулан /Хүснэгт-1/-д үзүүлээ.

Хүснэгт-1

Төв ЦБ-аас сорьц авсан цэг	pH	Ж/б мг/л	БПК ₅ мг/л	ПИЧ, мг/л	Нийт азот мг/л
MNS 4943:2015 /ЗДХ/	6-9	30	20	20	15
Гарах	8.20	127.2	94.2	97.3	9.3
Орох	8.00	127.2	109.9	119.3	
Цэвэршилт, хувь	14.3%				

Тайлбар: MNS4943:2015 хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтүүдийг тодруулав.

Цэвэршүүлээд гарч байгаа усан дахь бохирдуулах бодисын агууламжийг Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны стандарт MNS 4943:2015 дахь зөвшөөрөгдөх дээд агууламж (ЗДХ)-тай харьцуулахад гарах цэг нь БХХ₅-4.7 дахин Ж/Б-4.2 ПИЧ-4.8 дахин давсан үзүүлэлтэй байна. ЦБ-ийн шинжилгээний дүнгээр цэвэршүүлэлтийн хувь 14.3% байна.

Агаар бохирдлын эх үүсвэрийн аймгийн тоо бүртгэл: 2024 онд аймгийн хэмжээнд нийт гэрийн зуух 807 байдаг ба үүнээс гэрийн ердийн зуухны тоо 709, гэрийн сайжруулсан зуухны тоо 98, байшингийн ердийн зуухны тоо 386, байшингийн сайжруулсан зуухны тоо 86 бүртгэгдсэн байна. Гэрийн зууханд 4061 тн нүүрс, 844 м^3 мод, бусад 187 тн, байшин халаадаг зууханд 2527 тн нүүрс, 367 м^3 мод, бусад 162 тн түлшийг зарцуулсан байна.

Яндантай өрхийн тоо Сүмбэр суманд 1110 айл өрх, Баянтал суманд 79 айл өрх, Шивээговь суманд 90 айл өрх байгаа ба аймгийн хэмжээнд яндантай айл өрх 1279 байна.

График 1




График 2



2024 онд 3-15 кВт хүртэлх хүчин чадалтай зуухны тооллогыг зөвхөн сумдын бүх багийн оршин суудаг айл өрхийг хамруулан бүртгэсэн. 2024 онд 3-15 кВт хүчин чадалтай зуухны тооллогын нэгдсэн дүнгээр 2024 онд Сүмбэр сумын гэр, байшинтай айл өрхийн тоо өссөн, Шивээговь сумын гэр, байшинтай айл өрхийн тоо буурсан, Баянтал сумын байшинтай болон гэртэй айл өрхийн тоо өөрчлөгдөөгүй байна.

15-100 кВт-ын, 101-4200 кВт-с дээш хүчин чадалтай зуух аймгийн хэмжээнд нийт 40 аж ахуй нэгж байгууллага, 15-100 кВт-ын 19 аж ахуй нэгж байгууллага 1377 тн нүүрс, 101-4200 кВт-ийн хүчин чадалтай 21 аж ахуйн нэгж байгууллага 51168 тн нүүрсийг дулаан үйлдвэрлэхэд зарцуулсан байна. 2024 онд эдгээр зуухнаас нийт 6880 тн үнс хаягдаж байгууллагын дотоод нөөц бололцоогоор төвлөрсөн хогийн цэгт зайлуулдаг байна.

Сүмбэр сумын авто тээврийн хэрэгслийг 2023, 2024 оны тооллогын дүнтэй харьцуулахад өмнөх оныхоос нийт тээврийн хэрэгсэл 371 ширхгээр өсч цистерн 3, ачаа 78, суудал 262, зүтгүүр 21, тусгай зориулалт 9-өөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд нийт авто тээврийн хэрэгслийн 2023, 2024 оны дүнтэй харьцуулахад өмнөх оныхоос 371 ширхгээр өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн засаг даргын захирамжийн дагуу 7 Аж ахуйн нэгж байгууллагын 17-20 албан хаагчид Агаар бохирдуулагч эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журмын дагуу заавар зөвлөмж өгч хамтарч ажилласан.

Бусад ажил:

1. 3 дугаарын сарын 17-нд Цаг уур, орчны шинжилгээний газар болон БНСУлсын хамтарсан агаарын чанарын автомат багаж суурилуулахтай холбоотой 3 албан хаагч ирж пүтек байршуулах газар сонгон, цахилгааны хүчдэлийг шалгаж, агаарын чанарын автомат багажийн танилцуулах сургалт хийсэн. Сургалтад тус төвийн 3 албан хаагч хамрагдаж 2 дугаар улиралд багтаж байршуулахаар шийдвэрлэсэн.
2. Аймгийн архивын тасгаас зохион байгуулсан архив бичиг хэргийн сургалтад 1 албан



хаагч хамрагдсан.

3. Монгол улсад ус цаг, уурын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 101 жилийн ой, “Дэлхийн усны өдөр”, “Дэлхийн цаг уурын өдөр”-ийг тохиолдуулан “Эрт сэрэмжлүүлэх тогтолцоонд учрах саад бэрхшээлийг хамтдаа шийдэцгээе” эрдэм шинжилгээний бага хуралд байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.
4. Байгууллагын эзэмшлийн 50м газрын цэвэрлэгээг 14 хоног тутам хийж хоггүй сүмбэр пэйж хуудсанд байршуулсан.
5. Аймгийн удирдах ажилтнуудын 2025 оны 3 дугаарын 10-нд өгсөн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 03 дугаар сарын 17-нд байгууллагын эзэмшлийн талбайд мод, сөөгийг залуужуулах, хэлбэржүүлэх, таналт тайралтыг хийж ажлыг зохион байгуулсан



Тайлан гаргасан: УЦУОШТөвийн дарга

Ш.Мөнгөнцэцэг